

“ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ГУРАВДУГААР ҮЕ ШАТНЫ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Цэргийн төв эмнэлгийн Аврахуйн анагаах ухааны салбарт Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Яаралтай тусламжийн тасгууд харьяалагддаг бөгөөд Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв нь эрчимт эмчилгээний, ерөнхий эмчилгээний, цус цэвэршүүлэх эмчилгээний үндсэн 3 тасагт нийт 55 ортойгоор улсын хэмжээний эм химийн бодисын хурц хордлогын тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

Тус төвд жилд дунджаар 1500 орчим хүн эмчлэгдэж байгаагаас эрчимт эмчилгээ, яаралтай тусламжаар 400-500 орчим хүн үйлчлүүлдэг бөгөөд эдгээрийн 70% орчим нь хордлогын үеийн эрчимт эмчилгээний тусламж авдаг. Үлдэх хувь нь ерөнхий болон цус цэвэршүүлэх эмчилгээний тасгуудад эмчлэгддэг.

Хүснэгт 1. Тусламж үйлчилгээ болон тохиолдлын тоо - 2022-2024 он.

№	Тусламж үйлчилгээ	2022	2023	2024	2025
1	Эмийн хордлого	254	302	417	408
2	Химийн хордлого	116	258	271	246
3	Угаарын хордлого	726	1145	849	728
4	Архины хордлого	28	81	86	109
5	Хүйтэн зэвсэг	-	669	568	724
6	Халуун зэвсэг	-	10	8	9
7	Бусад гэмтэл	1028	659	662	1035

Дэлхийн улс орнуудын эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжил дэвшлийг даган гарч байгаа сөрөг тал нь олныг хамарсан үйлдвэрлэлийн ослууд, их хэмжээний түймэр, түүнийг дагалдан гарах угаарын, үйлдвэрлэлд хэрэглэгддэг химийн бодисуудын гаралтай хордлогууд, экологийн гаралтай хордлогууд болон орчин үеийн залуусын дунд тархаад байгаа хорт зуршил болох мансууруулах бодисын цочмог болон архаг хордлогод өртөгсдийн тоо жилээс жилд нэмэгдэж байна.

Тухайлбал Цэргийн төв эмнэлгийн Аврахуйн анагаах ухааны (Амь тэнссэн үеийн тусламж) төвд 2022 онд эм химийн болон угаарын хийн хордлогод өртөж хэвтэж эмчлэгдсэн хүний тоо 1096 байсан бол 2023 онд 1705, 2024 онд 1537, 2025 онд 1382 болж, урьд өмнөх жилүүдтэй харьцуулахад нэмэгдэж байгаа тул Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төвийн оношилгоо, эмчилгээнд хэрэглэж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчилж, нотолгоонд суурилсан орчин үеийн инновац шингэсэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нэн шаардлагатай байгаа нь энэхүү төслийн үндэслэл болж байна.

2. Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Төслийг хэрэгжүүлснээр ард иргэд, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар олон улсын стандартын шаардлагын түвшинд хүрч, үйлчлүүлэгчид үзүүлэх эмчилгээ, оношилгооны чадавхад томоохон хэмжээний ахиц, дэвшил гарна. Цэргийн албан хаагчид өндөр мэдрэмжит шинжилгээ, үйлчилгээнд хамрагдахын тулд бусад эмнэлэгт хандахгүйгээр эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнээр түргэн шуурхай оношилгоо, эмчилгээнд хамрагдах боломж бүрдэнэ.

Төслийг хэрэгжүүлснээр тус эмнэлэгт урд өмнө нь хийгдэх боломжгүй байсан оношилгоо, эмчилгээнүүдийг хийж, ард иргэдийн гадаад орон руу явж эмчлүүлэх урсгалыг багасгаж, эх орондоо харьцангуй хямд өртгөөр эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

---oOo---